

**ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БЭЛТГЭСЭН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Шийдвэрийн төслийн нэр: Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай

	Гарын үсэг:	Албан тушаал, нэр	Огноо:
1 Зөвшөөрсөн:	.....	/СЗХ-ны дарга С.Даваасүрэн/	.....
2 Танилцсан:	.....	/СЗХ-ны гишүүн, дэд дарга Д.Баярсайхан /	.....
	.....	/СЗХ-ны гишүүн, дэд дарга О.Батбилэг/	.....
3 Хянасан:	.....	/Ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Жамбаажамц/	.....
	.....	Хууль, эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрхэмбаяр/	.....
	.....	/Банк бус санхүүгийн байгууллагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Баянцогт/	.....
	.....	/Банк бус санхүүгийн байгууллагын газрын орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Итгэлсүрэн/	.....
	.....	/Банк бус санхүүгийн байгууллагын газрын ахлах референт Н.Оюунчимэг/	.....
4 Төсөл боловсруулсан:	.....	/Банк бус санхүүгийн байгууллагын газрын мэргэжилтэн Ч.Батцэцэг /	.....
5 Хуралдаанд гаднаас оролцох төлөөлөгч:	<u>Нэр:</u>	<u>Байгууллага:</u>	<u>Албан тушаал:</u>
6 Төслийг хүлээн авч, олшруулахыг зөвшөөрсөн:		Захиргаа удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батзориг	Гарын үсэг: ..... Огноо .....

Санал:

Санал 1	Санал 2	Санал 3

Гарын үсэг, огноо

.....

Гарын үсэг, огноо

.....

Гарын үсэг, огноо

.....

Баримтын төрөл:Тогтоолын төсөл

Огноо: 2017.03.06

Хянасан:

АА-ны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.....Т.Жамбаажамц

ЭЗХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч .....Э.Эрхэмбаяр

ББСБГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.....С.Баянцогт

ББСБГ-ын орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.....Б.Итгэлсүрэн

ББСБГ-ын ахлах референт.....Н.Оюунчимэг

Боловсруулсан:

ББСБГ-ын мэргэжилтэн.....Ч.Батцэцэг

**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2017 оны .. сарын .. өдөр

Дугаар \_\_\_\_\_

Улаанбаатар хот

Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам /цаашид журам гэх/-ын 3.2, 5.2, 5.3 дахь хэсгийн "Валют арилжааны ББСБ" гэснийг "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6, 7.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх этгээд" гэж, 3.3, 4.3,5.2, 5.3 дахь хэсгийн "Зээл санхүүжилтийн ББСБ" гэснийг "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.7, 7.1.9-д заасан үйл ажиллагаа эрхлэх этгээд" гэж, 3.4, 4.4, 5.2, 5.3 дахь хэсгийн "Хөрөнгө удирдлагын ББСБ" гэснийг "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх этгээд" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Журмын "16-а" дугаар хавсралтын "Валют арилжааны ББСБ-ын" гэснийг "журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх этгээд", "16-б" дүгээр хавсралтын "Зээл санхүүжилтийн ББСБ-ын" гэснийг "журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх этгээд", "16-в" дүгээр хавсралтын "Хөрөнгө удирдлагын ББСБ-ын" гэснийг "журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх этгээд" гэж тус тус өөрчилсүгэй.

3. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг дээрх журмын дагуу тооцож, мөрдөж ажиллах, холбогдох санхүүгийн тайланг улирал (сар) бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байхыг банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОЖ,  
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ  
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шаардлагыг банк бус санхүүгийн байгууллага (цаашид ББСБ гэх) хэрхэн биелүүлж байгааг тооцох зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоож, түүний биелэлтэд хяналт тавих, холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэхэд оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. “Банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө” гэдэгт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг;

“Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэдэгт хувьцаат капитал дахь энгийн хувьцаа болон халаасны хувьцаа, энгийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал, цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сан, хуримтлагдсан ашиг, алдагдал, хандивын капитал зэргийг;

“Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэдэгт хувьцаат капитал дахь давуу эрхтэй хувьцаа, давуу эрхтэй хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал, дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан, борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан, хоёрдогч өглөг зэргийг;

1.2.2. “Өөрийн хөрөнгийн хүрэлцээ” гэдэгт ББСБ нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсэхийг тодорхойлсон үнэлгээг;

1.2.3. “Хоёрдогч өглөг” гэдэгт өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, 3-дагч этгээдээс авсан мөнгөн хөрөнгийг;

1.2.4. “Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар” (цаашид “ТТГЧ” гэх) гэдэгт бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг;

1.2.5. “Гадаад валютын ханшийн эрсдэл” гэдэгт төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэлийг;

1.2.6. “Зах зээлийн эрсдэл” гэдэгт гадаад валютын ханш, хүү болон үнийн хэлбэлзлээс алдагдал хүлээх эрсдэлийг;

1.3. ББСБ нь өөрийн үйл ажиллагааны бүх төрлийн эрсдэлийг үнэлэх, хяналт тавин удирдах зорилгоор дээр дурдагдсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс гадна бусад журам, зааврыг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулж, дотооддоо мөрдүүлж болно.

ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ  
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ

2.1. ББСБ-ын эрсдэлийн ерөнхий түвшин нь ББСБ-ын нэгтгэлийн дундаж үзүүлэлтээс өндөр байвал Хорооны даргын шийдвэрээр ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны үзүүлэлтийн байвал зохих доод хувь хэмжээг энэхүү журамд зааснаас дээгүүр тогтоож болно.

2.2. ББСБ-ын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцохдоо дараах байдлаар тохируулсан байна. Үүнд:

2.2.1. урьдчилж төлсөн татварын дүнг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасах;

2.2.2. хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүнгээс хэтрэхгүй байх, хэтэрсэн дүнг өөрийн хөрөнгийн дүнгээс хасах;

2.2.3. ББСБ нь татан буугдсан тохиолдолд хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хамрагдах хоёрдогч өглөгийг барагдуулах дараалал нь Иргэний хуулийн 32.5.6 дугаар зүйлд зааснаар зохицуулагдах;

2.2.4. урьдчилсан болон дараалсан хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд бүртгэж, өөрийн хөрөнгийг хорогдуулах буюу нэмэгдүүлэн бодит дүнг гаргах.

2.3. Эрсдэлээр жигнэсэн нийт активын дүнг тооцохдоо тэнцлийн активууд болон тэнцлийн гадуур бүртгэлтэй байгаа бусдын өмнө хүлээж болзошгүй үүргүүдийн дүнг энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан эрсдэлийн хувь хэмжээгээр үржүүлж, гарах нийлбэр дүнг дараах байдлаар тохируулна.

2.3.1. гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, харилцахын эрсдэлийн хувь хэмжээг Стандарт энд Пурс (Standard & Poors), Мууди (Moody's), Фич (Fitch) зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон рейтингийг ашиглан дараах хүснэгтийг үндэслэн тооцно.

Стандарт энд Пурс	AAA/AA-	A+/A-	BBB+/BBB-	BB+/B-	B- бага	Рейтинггүй банк
Фич	AAA/AA3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
Мууди	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	
Урт хугацаат авлага (3 сараас дээш)	20%	50%	50%	100%	150%	100%
Богино хугацаат авлага (3 сараас доош)	20%	20%	20%	50%	150%	100%

2.3.2 гадаад валютын ханшийн эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлыг тооцохдоо гадаад валютын нээлттэй позицийн дүнг нэмнэ.

2.3.3 үйл ажиллагааны эрсдэлээс учирч болзошгүй хохирлоос сэргийлэхийн тулд ББСБ нь сүүлийн 3 жилийн татварын өмнөх эерэг ашгийн дунджийн 15 хувийг тухайн ББСБ-д мөрдөж байгаа өөрийн хөрөнгийн шаардлагын урвуугаар үржүүлэн нэмнэ.

2.4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активын дүнг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнд харьцуулах замаар тооцох буюу төгрөг, гадаад валют болон тэдгээрийн нийлбэр дүнгээр нь тус тус тодорхойлно.

2.4.1. түргэн борлогдох активыг касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж, харилцах дансны үлдэгдэл, засгийн газрын үнэт цаасны нийлбэрээр тооцно.

2.4.2. бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг банк, санхүүгийн байгууллага, төслийн санхүүжилтээр авсан зээл, зээлийн хүүгийн өглөг, итгэлцлийн, факторингийн болон мөнгөн гуйвуулга, цахим төлбөр тооцооны үйлчилгээгээр үүссэн өглөг, ББСБ-аас гаргасан хувьцаанд хөрвөх өрийн бичиг, бусад пассив дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

2.5. Зээл, түүнтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн газарзүйн байршил, эдийн засгийн салбар, зориулалт, барьцаа хөрөнгө болон батлан даагч аж ахуйн нэгжтэй холбоотой төвлөрлийн эрсдэлийг зохих түвшинд нь барьж байх хязгаарлалтыг ББСБ өөрөө тогтоож, дотооддоо мөрдүүлнэ.

2.6. Тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансанд бүртгэлтэй нийт гадаад валютын актив, пассивын зөрүүг өөрийн хөрөнгөд харьцуулан гадаад валютын эрсдэлийг тооцно.

2.6.1. гадаад активт банк, санхүүгийн байгууллага дахь гадаад валютын харилцах, хадгаламж, касс дахь бэлэн валют, гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, түүнтэй адилтган тооцох активын үлдэгдэл болон бусад актив багтана.

2.6.2. гадаад пассивт гадаад валютаар илэрхийлэгдсэн итгэлцлийн үйлчилгээний өглөг, бусдаас авсан зээл, төслийн зээл, гаргасан өрийн бичиг, бусад өглөгүүд, тэнцлийн гадуурх дансны үлдэгдэлд гадаад валютаар гаргасан бүх төрлийн төлбөрийн баталгаанууд хамаарна.

2.7. Гадаад валютаар бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлээгүй бөгөөд гадаад валютаар илэрхийлэгдэх актив хөрөнгөгүй, зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын хувьд дээрх үзүүлэлтийг тооцох шаардлагагүй буюу хангаж ажилласан гэж үзнэ.

2.8. Өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаа явуулж буй тохиолдолд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг тооцох шаардлагагүй буюу хангаж ажилласан гэж үзнэ.

2.9. ББСБ-ын цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүнг нийт активт харьцуулан үндсэн хөрөнгийн үзүүлэлтийг тооцно.

2.10. ББСБ нь өрийн бичгийн зохистой харьцааны үзүүлэлтийг тооцохдоо гаргасан өрийн бичгийг өөрийн хөрөнгөд харьцуулах замаар тооцно.

2.11. Итгэлцлийн үйлчилгээний зохистой харьцааны үзүүлэлтийг тооцохдоо итгэлцлийн үйлчилгээний өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулах замаар тооцно.

2.12. Хөрөнгө /актив/-ийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөжийг ББСБ-уудад ижил тооцох бөгөөд активын өгөөжийг тооцохдоо тайлант үеийн татварын дараах цэвэр ашгийг нийт активын дундаж /өмнөх оны мөн үеийн актив дүн дээр тайлант үеийн активын дүнг нэмж дундажласан дүн/-тай, өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцохдоо тайлант үеийн татварын дараах цэвэр ашгийг өөрийн хөрөнгийн дундаж /өмнө оны мөн үеийн өөрийн хөрөнгө дээр тайлант үеийн өөрийн хөрөнгийг нэмж дундажласан дүн/-тай харьцуулах замаар тус тус тооцно.

## ГУРАВ. ББСБ-ЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

3.1. ББСБ нь дор дурдсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг нийтээр хангаж ажиллана. Үүнд:

3.1.1. төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 8 хувиас доошгүй;

3.1.2. өрийн бичгийн зохистой харьцаа нь өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй;

3.1.3. цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн нь нийт хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй;

3.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6, 7.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дор дурдсан нэмэлт зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллана. Үүнд:

3.2.1. нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активт харьцуулсан харьцаа /цаашид НЗӨХ гэх/ нь 30 хувиас доошгүй;

3.2.2. өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активт харьцуулсан харьцаа /цаашид НӨХ гэх/ нь 40 хувиас доошгүй;

3.2.3. нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нийт активт харьцуулсан харьцаа /цаашид НАХ гэх/ нь 30 хувиас доошгүй;

3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.7,7.1.9-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дор дурдсан нэмэлт зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллана. Үүнд:

3.3.1. НЗӨХ нь 20 хувиас доошгүй;

3.3.2. НӨХ нь 30 хувиас доошгүй;

3.3.3. НАХ нь 20 хувиас доошгүй;

3.3.4. зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активын эрсдэлийн санг “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу тооцож байгуулна.

3.3.5. нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй;

3.3.6. ББСБ-ын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд тэдгээртэй холбогдох этгээд болон Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны дээд хэмжээ нь өөрийн хөрөнгийн 10 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй;

3.3.7. ББСБ-ын худалдан авах үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь ББСБ-ын өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй бөгөөд энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 10 хувиас хэтрэхгүй;

3.3.8. ББСБ-ын гаргасан төлбөрийн баталгааны нийт дүн өөрийн хөрөнгийн 70 хувиас хэтрэхгүй;

3.3.9. гадаад валютын актив пассивын зохистой харьцаа нь нийт валютын хувьд өөрийн хөрөнгийн +/- 40 хувиас хэтрэхгүй;

3.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 3.1-д зааснаас гадна дор дурдсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллана. Үүнд:

3.4.1. НЗӨХ нь 10 хувиас доошгүй;

3.4.2. НӨХ нь 20 хувиас доошгүй;

3.4.3. НАХ нь 10 хувиас доошгүй;

3.4.4. зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активын эрсдэлийн санг энэ журмын 3.3.4-т заасны дагуу;

3.4.5. нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь энэ журмын 3.3.5-т заасны дагуу;

3.4.6. ББСБ-ын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтнууд тэдгээртэй холбогдох этгээд болон Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-д заасан этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны дээд хэмжээ болон тэдгээрийн нийлбэр дүн нь энэ журмын 3.3.6-д заасны дагуу;

3.4.7. ББСБ-ын худалдан авах үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй;

3.4.8. ББСБ нь зөвхөн Монголын хөрөнгийн биржийн "А" самбарын компанийн хувьцаанд хөрөнгө оруулж болох ба худалдан авсан компанийн хувьцааны нийт дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд энэ нь нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 20 хувиас дээшгүй;

3.4.9. Компанийн өрийн бичгийн худалдан авах нийт дүн ББСБ-ын өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй;

3.4.10. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах нийт дүн ББСБ-ын өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй;

3.4.11. ББСБ-ын гаргасан төлбөрийн баталгааны нийт дүн энэ журмын 3.3.8-д заасны дагуу;

3.4.12. гадаад валютын актив пассивын зохистой харьцаа нь энэ журмын 3.3.9-д заасны дагуу;

3.4.13. итгэлцлийн үйлчилгээний өглөгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа нь 80 хувиас хэтрэхгүй;

#### ДӨРӨВ. БУСАД

4.1. ББСБ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг энэ журмын хавсралтын дагуу улирал бүр тооцож, тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ. Үүнд:

4.1.1. хураангуй тайлан, тэнцэл;

4.1.2. үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

4.1.3. өөрийн хөрөнгө, нийт эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны тайлан /хавсралт 1/;

4.1.4. төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан / хавсралт 2/;

4.1.5. өрийн бичгийн тайлан /хавсралт 12/;

4.1.6. банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөр, бусад эх үүсвэрээс татсан зээлийн тайлан /хавсралт 11/;

4.1.7. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайлан /хавсралт 15/;

4.2. Энэ журмын 4.1-т зааснаас гадна сар тутмын валют арилжааны мэдээг энэ журмын 17-р хавсралтын дагуу, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тайланг энэ журмын 15-р хавсралтын дагуу гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороо, Монголбанкинд ирүүлнэ.

4.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.7,7.1.9-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 4.1, 4.2-т зааснаас гадна дараах тайланг улирал бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор, 4.3.6-д заасан тайланг зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн чанарын багцын хамт сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

*/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 269 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан / Үүнд:*

4.3.1. гадаад валютын ханшийн эрсдэлийн тайлан /хавсралт 3/;

4.3.2. активын эрсдэлийн сангийн хүрэлцээ, хангамжийн судалгааны тайлан /хавсралт 4/;

4.3.3. хөрөнгө эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацааны тайлан /хавсралт 5/;

4.3.4. ББСБ-ын 40 том зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив /санхүүгийн түрээс, факторинг/ хөрөнгийн тайлан /хавсралт 6/;

4.3.5. ББСБ-ын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив /санхүүгийн түрээс, факторинг/ хөрөнгийн тайлан /хавсралт 7/;

4.3.6. зээл олголт, эргэн төлөлт, зээлийн зориулалт, хүүгийн судалгааны тайлан /хавсралт 8/;

4.3.7. ипотекийн зээлийн тайлан /хавсралт 9/;

4.3.8. үнэт цаасны төвлөрлийн тайлан /хавсралт 10/;

4.3.9. өрийн бичгийн тайлан /хавсралт 12/;

4.3.10. тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүрэг, төлбөрийн баталгааны судалгааны тайлан /хавсралт 14/;

4.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд нь энэ журмын 4.1, 4.2, 4.3-т зааснаас гадна итгэлцлийн үйлчилгээний төвлөрлийн тайлан /хавсралт 13/-г сар, улирал бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

*/ Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 269 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан /*

#### ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1. ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд Хороо сар, улирал тутам хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгалт хийх болон "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 7.1, 7.2, 7.6, 7.7 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ авна.

5.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6, 7.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьд НЗӨХ нь 15-29, НӨХ нь 20-39, НАХ нь 15-29 хүртэл хувь; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.7, 7.1.9-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьд НЗӨХ нь 10-19, НӨХ нь 15-29, НАХ нь 10-19; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьд НЗӨХ нь 5-9, НӨХ нь 10-19, НАХ нь 5-9 хүртэл хувь бол өөрийн хөрөнгийн дутагдалтай гэж үзэн дараах арга хэмжээг авна. Үүнд:

5.2.1. албан бичгээр анхааруулах;

5.2.2. зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх;

5.2.3. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийг шаардах;

5.2.4. салбар шинээр байгуулах, нэмэлт үйл ажиллагаа эрхлэхийг хориглох;

5.3 Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.6, 7.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьд НЗӨХ нь 1-14, НӨХ нь 1-19, НАХ нь 1-14 хүртэл хувь; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.7, 7.1.9-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн хувьд НЗӨХ нь 1-9, НӨХ нь 1-14, НАХ нь 1-9; Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.1-7.1.11-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд-ын хувьд НЗӨХ нь 1-5, НӨХ нь 1-9, НАХ нь 1-4 хүртэл хувь бол өөрийн хөрөнгийн хэмжээ алдагдаж байна гэж үзэн дараах арга хэмжээг авна. Үүнд:

5.3.1. алдагдал учруулж буй зарим үйл ажиллагааг түр буюу бүрэн зогсоох;



5.3.2. ногдол ашиг хуваарилахыг түдгэлзүүлэх;

5.3.3. бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлэхийг хориглох.

5.4. НӨХ нь 0 хувиас бага бол анх удаа хамрагдсан байдлыг үл харгалзан ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

5.5. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгөгдсөн үүрэг даалгавар, шаардлагыг биелүүлж ажиллаагүй ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.

5.6. Хорооноос дээрх арга хэмжээнүүдийг хүлээлгэхдээ адил зөрчилд адил арга хэмжээ авах зарчмыг баримтална.

5.7. ББСБ нь Хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Хорооны Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно. Албадлагын арга хэмжээ ногдуулсан нь бусад хууль тогтоомжийн дагуу хүлээлгэх хариуцлагаас ББСБ-ыг чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.8. Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Хорооны улсын байцаагч эрх хэмжээнийхээ хүрээнд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 20.2-т заасны дагуу захиргааны хариуцлага ногдуулна.

-- ооОоо --

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 1

**ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		НИЙТ ДҮН		
<b>А</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ /AI+AIH/</b>			-
<b>I. I зэрэглэлийн өөрийн хөрөнгө</b>				-
1	Энгийн хувьцаа			-
2	Халаасны хувьцаа			-
3	Энгийн хувьцаанаас нэмэгдэж төлөгдсөн капитал			-
4	Хандивын капитал			-
5	Нөөцийн сан			-
6	Тухайн үеийн ашиг/алдагдал			-
7	Хуримтлагдсан ашиг/алдагдал			-
8	Тохируулга*			-
<b>Дүн /тохируулга/</b>				-
<b>II. II-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө</b>				-
9	Давуу эрхтэй хувьцаа			-
10	Дахин үнэлгээний нэмэгдэл			-
11	Нийгмийн хөгжлийн сан			-
12	Хоёрдогч өглөг			-
<b>Б</b>	<b>ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН АКТИВЫН ДҮН</b>	<b>Эрсдэлийн түвшин</b>	<b>Ня-бо тайлан тэнцлийн нийт актив</b>	<b>Эрсдэлээр жигнэсэн</b>
<b>I. Активын дүн</b>				
1	Касс дахь бэлэн мөнгө	0%	-	-
2	Замд яваа мөнгө	20%	-	-
3	Тоолж шалгаагүй бэлэн мөнгө	0%	-	-
4	Дотоодын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	20%	-	-
5	Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	20%	-	-
6	Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	50%	-	-
7	Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	100%	-	-
8	Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	150%	-	-
9	Засгийн газрын үнэт цаас /цэврээр/	0%	-	-
10	Төв банкны үнэт цаас /цэврээр/	0%	-	-
11	Бусад үнэт цаас /цэврээр/	100%	-	-
12	Зээлийн өрийн үлдэгдэл /цэврээр/	100%	-	-
13	Санхүүгийн түрээсийн авлага /цэврээр/	100%	-	-
14	Факторингийн тооцооны авлага /цэврээр/	100%	-	-
15	Өмчлөх бусад үндсэн хөрөнгө /цэврээр/	100%	-	-
16	Үндсэн ба биет бус хөрөнгө /цэврээр/	100%	-	-
17	Бусад актив /цэврээр/	100%	-	-
<b>II. Тэнцлийн гадуурх дансны дүн</b>				
18	Хүлээж болзошгүй үүргүүд /төлбөрийн баталгаа, зээлийн шугам/	100%	-	-
<b>III Сүүлийн гурван жилийн эерэг ашигын дундаж</b>				-
<b>В</b>	<b>НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА</b>			
1	Харьцаа тайлангаар			-
2	Харьцааны биелэгдээгүй хувь			-
<b>Г</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА</b>			
1	Харьцаа тайлангаар			-
2	Харьцааны биелэгдээгүй хувь			-
<b>Д</b>	<b>НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА</b>			
1	Харьцаа тайлангаар			-
2	Харьцааны биелэгдээгүй хувь			-

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

**ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ТӨГРӨГ	ГАДААД ВАЛЮТ	НИЙТ ДҮН
<b>А. ТҮРГЭН БОРЛОГДОХ АКТИВ</b>		-	-	-
1	Касс дахь бэлэн мөнгө	-	-	-
2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	-	-	-
3	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж	-	-	-
4	Засгийн газрын үнэт цаас	-	-	-
5	Төв банкны үнэт цаас	-	-	-
<b>Б. БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ</b>		-	-	-
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	-	-	-
2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	-	-
3	Төслийн зээлийн санхүүжилтээр авсан зээл	-	-	-
4	Бусад эх үүсвэр	-	-	-
5	Бусад пассив	-	-	-
<b>В. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>		<b>8.0%</b>	<b>8.0%</b>	<b>8.0%</b>
1	Харьцаа тайлангаар	-	-	-
2	Харьцааны биелэгдээгүй хувь	-	-	-

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 3

**ГАДААД ВАЛЮТЫН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ВАЛЮТЫН ТӨРӨЛ									НИЙТ ДҮН		
	USD	EUR	JPY	CHF	GBP	CNY	RUB	KRW	Бусад	Ам.доллар	Төгрөг	
<b>А. АКТИВ</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1 Бэлэн валют												
2 Банк, санхүүгийн байгууллага дахь гадаад валютын харилцах, хадгаламжийн данс												
3 Валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл												
4 Санхүүгийн түрээс /валютаар/												
5 Факторингийн авлага /валютаар/												
6 Бусад												
<b>Б. ПАССИВ</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1 Итгэлцлийн үйлчилгээний өглөг												
2 Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл												
3 Төслийн зээлийн санхүүжилт												
4 Өрийн бичиг												
5 Бусад гадаад эх үүсвэр												
6 Бусад өр төлбөр												
<b>В. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСДЫН ҮЛДЭГДЭЛ</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1 Төлбөрийн баталгаанууд												
2 Бусад хүлээж болзошгүй үүргүүд												
<b>Г. ВАЛЮТЫН ДАНСНЫ ЦЭВЭР ЗӨРҮҮ</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
I. Тэнцлийн дансуудаар (А-Б)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
II. Тэнцлийн гадуурх дансуудаар (В)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Д. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (тухайн валютаар)</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Е. ВАЛЮТЫН ДАНСНЫ ЦЭВЭР ЗӨРҮҮ/ӨХ</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Байвал зохих хувь	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%	+/-40%
Монголбанкны албан ханш	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 4

**АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ, ХАНГАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТҮҮД					НИЙТ ДҮН	
Д/д	Хөрөнгийн ангилал	Үлдэгдэл	Эрсдэлийн сангийн хувь	Байгуулбал зохих сан	Байгуулсан сан	Илүү (+) дутуу (-)
<b>А.</b>	<b>Нийт зээл</b>	-	<b>100%</b>	-		
1	Хэвийн зээл	-	0%	-		
2	Хугацаа хэтэрсэн зээл	-	5%	-		
3	Чанаргүй зээл:	-		-	-	-
	а/ Хэвийн бус	-	25%	-		
	б/ Эргэлзээтэй	-	50%	-		
	в/ Муу	-	100%	-		
<b>Б.</b>	<b>Нийт санхүүгийн түрээс</b>	-	<b>100%</b>	-		
4	Хэвийн санхүүгийн түрээс	-	0%	-		
5	Хугацаа хэтэрсэн санхүүгийн түрээс	-	5%	-		
6	Чанаргүй санхүүгийн түрээс:	-		-	-	-
	а/ Хэвийн бус	-	25%	-		
	б/ Эргэлзээтэй	-	50%	-		
	в/ Муу	-	100%	-		
<b>В.</b>	<b>Нийт факторинг</b>	-	<b>100%</b>	-		
7	Хэвийн факторинг	-	0%	-		
8	Хугацаа хэтэрсэн факторинг	-	5%	-		
9	Чанаргүй факторинг:	-		-	-	-
	а/ Хэвийн бус	-	25%	-		
	б/ Эргэлзээтэй	-	50%	-		
	в/ Муу	-	100%	-		
<b>Г.</b>	<b>Нийт авлага</b>	-	<b>100%</b>	-		
10	Хэвийн авлага	-	0%	-		
11	Хугацаа хэтэрсэн авлага	-	5%	-		
12	Чанаргүй авлага:	-		-	-	-
	а/ Хэвийн бус	-	25%	-		
	б/ Эргэлзээтэй	-	50%	-		
	в/ Муу	-	100%	-		
<b>Д.</b>	<b>Үнэт цаас</b>	-	<b>0%</b>	-	-	-
<b>Е.</b>	<b>Нийт ӨБҮХХ</b>	-	<b>100%</b>	-		
13	Хэвийн ӨБҮХХ	-	0%	-		
14	Хугацаа ӨБҮХХ	-	5%	-		
15	Чанаргүй ӨБҮХХ. Үүнээс:	-		-	-	-
	а/ Хэвийн бус	-	25%	-		
	б/ Эргэлзээтэй	-	50%	-		
	в/ Муу	-	100%	-		
<b>Ё.</b>	<b>Хүлээж болзошгүй үүргүүд /төлбөрийн баталгаа/</b>	-	<b>0%</b>	-		
<b>НИЙТ</b>		-		-	-	-

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 5

**ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНЫ ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Хөрөнгө		Хугацаагүй	1 сар хүртэл	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-3 жил	3-5 жил	5 жилээс дээш	Нийт
1	Бэлэн мөнгө									
2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах									
3	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж									
4	Зээл									
5	Хөрөнгө оруулалт									
6	Факторинг									
7	Авлага									
8	Бусад актив									
<b>НИЙТ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ</b>										
<b>Өр төлбөр</b>										
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг									
2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл									-
3	Бусад эх үүсвэр									-
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг									-
5	Төслийн зээлийн санхүүжилт									-
6	Хоёрдогч өглөг									-
<b>НИЙТ САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР</b>										
Цэвэр зөрүү										
Цэвэр зөрүү (өссөн дүнгээр)										
<b>Хөрөнгө, өр төлбөрийн зөрүүг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа</b>										
		-	-	-	-	-	-	-	-	-

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
 хяналт тавих журам"-ын хавсралт 6

**ББСБ-ЫН 40 ТОМ ЗЭЭЛДЭГЧИД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ /САНХҮҮГИЙН ТҮРЭЭС, ФАКТОРИНГ/ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

№	Зээлдэгчийн нэр	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгө /актив/-ийн эхний үлдэгдэл	Зориулалт	Олгосон огноо	Төлөгдөх огноо	Хугацаа сунгасан төлөгдөх огноо	Барьцаа хөрөнгийн төрөл	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгө /актив/-ийн эцсийн үлдэгдэл	Төгрөг зээл валлотын зээлийн аль нь болох	Хөрөнгө /актив/-ийн ангилал	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1												-
2												-
3												-
4												-
5												-
6												-
7												-
8												-
9												-
10												-
.												-
.												-
.												-
.												-
.												-
.												-
.												-
.												-
.												-
.												-
.												-
40												-
<b>НИЙТ</b>		-						-	-			-

Хамгийн том зээлдэгч -

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
 ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 7

**ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАНД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ  
/САНХҮҮГИЙН ТҮРЭЭС, ФАКТОРИНГ/ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

№	Зээлдэгчийн нэр	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгө /актив/-ийн эхний үлдэгдэл	Зориулалт	Олгосон огноо	Төлөгдөх огноо	Хугацаа сунгасан төлөгдөх огноо	Барьцаа хөрөнгийн төрөл	Барьцаа хөрөнгийн үнэлгээ	Зээл, зээлтэй адилтган тооцох бусад хөрөнгө /актив/-ийн эцсийн үлдэгдэл	Төгрөгийн зээл валютын зээлийн аль нь болох	Хөрөнгө /актив/-ийн ангилал	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1												-
2												-
3												-
4												-
5												-
6												-
7												-
8												-
9												-
10												-
11												-
12												-
13												-
14												-
15												-
16												-
17												-
18												-
19												-
20												-
<b>НИЙТ</b>		-						-	-			

Хамгийн том зээлдэгч

-

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/

ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/





2.4 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж													
2.5 Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа													
2.6 Барилга													
2.7 Бөөний болон жижиглэн худалдаа													
2.8 Машин мотоциклийн засвар үйлчилгээ													
2.9 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа													
2.10 Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа													
2.11 Мэдээлэл холбоо													
2.12 Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа													
2.13 Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа													
2.14 Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа													
2.15 Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа													
2.16 Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал													
2.17 Боловсрол													
2.18 Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа													
2.19 Бусад													
Үүнээс: Хэрэглээ, цалин, тэтгэвэр, хадгаламж барьцаалсан зээл													
<b>НИЙТ</b>													

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/

ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/





"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 10

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРЛИЙН ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Нэр төрөл	Худалдан авсан дүн	Худалдан авсан огноо	Зарсан огноо	Тайлант үеийн үлдэгдэл	Тухайн компанийн гаргасан хувьцааны нийт дүн	Тухайн компанийн гаргасан хувьцааны 10%	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1							0.0	-
2							0.0	-
3							0.0	-
4							0.0	-
5							0.0	-
6							0.0	-
7							0.0	-
8							0.0	-
9							0.0	-
10							0.0	-
11							0.0	-
12							0.0	-
13							0.0	-
14							0.0	-
15							0.0	-
16							0.0	-
17							0.0	-
18							0.0	-
19							0.0	-
20							0.0	-
<b>НИЙТ</b>		-			-	-	<b>0.0</b>	<b>-</b>

Хамгийн их эзэмшлийн дүн

-

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/

ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
 хяналт тавих журам"-ын хавсралт 11

**БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, БУСАД ЭХ ҮҮСВЭРЭЭС ТАТСАН ЗЭЭЛИЙН ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Зээлдүүлэгчийн нэр	Зээлийн эхний үлдэгдэл	Хүү	Авсан огноо	Төлөгдөх огноо	Хугацаа сунгасан	Зээлийн ангилал	Барьцаа хөрөнгө	Зээлийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн зээлийн өр	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1											-
2											-
3											-
4											-
5											-
6											-
7											-
8											-
9											-
10											-
11											-
12											-
13											-
14											-
15											-
16											-
17											-
18											-
19											-
20											-
<b>НИЙТ</b>		-							-	-	-

Хамгийн том зээлдүүлэгч

-

-

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
 ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
 хяналт тавих журам"-ын хавсралт 12

**ӨРИЙН БИЧГИЙН ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Эзэмшигчийн овог нэр	Өрийн бичгийн өглөгийн дүн	Хүү	Хугацаа	Гаргасан огноо	Төлөгдөх огноо	Үлдэгдэл	Өрийн бичигт эзлэх хувь
1								-
2								-
3								-
4								-
5								-
6								-
7								-
8								-
9								-
10								-
11								-
12								-
13								-
14								-
15								-
16								-
17								-
18								-
19								-
20								-
<b>НИЙТ</b>		-					-	

Хамгийн их -

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
 ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 13

**ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВЛӨРЛИЙН ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Итгэмжлэгчийн овог нэр	Өглөгийн дүн	Хугацаа /жилээр/	Эхэлсэн огноо	Төлөгдөх огноо	Хугацаа сунгасан огноо	Өглөгийн эцийн үлдэгдэл	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1								-
2								-
3								-
4								-
5								-
6								-
7								-
8								-
9								-
10								-
11								-
12								-
13								-
14								-
15								-
16								-
17								-
18								-
19								-
20								-
<b>НИЙТ</b>		-					-	

Хамгийн их

-

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/



**ТЭНЦЛИЙН ГАДУУР БҮРТГЭЛТЭЙ ХҮЛЭЭЖ БОЛЗОШГУЙ ҮҮРЭГ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Дансны дугаар	ААН-ын нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Баталгааны зориулалт	ААНБ захирлын нэр	Регистрийн дугаар	ББСБ-тай ямар холбоотой болох*	Хугацаа			Дүн		Өөрийн хөрөнгөд эзлэх хувь			
									Гаргасан	Төлөгдөх	Сунгасан	Төгрөг	Валют				
1															-		
2															-		
3															-		
4															-		
5															-		
<b>ДҮН</b>														-	-		
1															-		
2															-		
3															-		
4															-		
5															-		
<b>ДҮН</b>														-	-		
1															-		
2															-		
3															-		
4															-		
5															-		
<b>ДҮН</b>														-	-		
<b>НИЙТ</b>															-	-	

Хамгийн их -

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

**ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО, МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/CC/ӨӨ

(мянган төгрөгөөр)

Д/д	Валютын төрөл	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ /тайлант үеэр/						Хувь
		Шилжүүлсэн			Хүлээн авч олгосон			
		Валютын дүн	Гүйлгээний тоо	Төгрөгт хөрвүүлсэн дүн	Валютын дүн	Гүйлгээний тоо	Төгрөгт хөрвүүлсэн дүн	
1	USD							-
2	EUR							-
3	JPY							-
4	CHF							-
5	GBP							-
6	CNY							-
7	RUB							-
8	KRW							-
9	Бусад валют							-
<b>НИЙТ</b>		-	-	-	-	-	-	-
							<b>Хамгийн их</b>	-

ТАМГА

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 16-а

**ЖУРМЫН 3.2-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН  
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
<b>А.</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>			
1	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	30%-аас доошгүй	-	
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	40%-аас доошгүй	-	
3	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	30%-аас доошгүй	-	
<b>Б.</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>			
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	-	
<b>Е.</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
5	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	-	
<b>Ё.</b>	<b>ӨРИЙН БИЧГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
6	ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	-	
<b>Ж.</b>	<b>ӨГӨӨЖ</b>			
7	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			-
8	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ			-

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

"Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны  
зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож,  
хяналт тавих журам"-ын хавсралт 16-б

**ЖУРМЫН 3.3-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН  
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
<b>А.</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>			
1	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	-	
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	30%-аас доошгүй	-	
3	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	-	
<b>Б.</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>			
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	-	
<b>В.</b>	<b>АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
5	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү,- дутуу)	-	-	
6	НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	-	
7	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, АЖИЛТАН, ХОЛБОГДОХ НЭГ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	-	
8	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, АЖИЛТАН, ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ НИЙЛБЭР ДҮНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25%-аас хэтрэхгүй	-	
9	ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШИЛ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	-	
10	НЭГ КОМПАНИЙН ГАРГАСАН ХУВЬЦААНААС ХУДАЛДАЖ АВАХ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	-	
11	ББСБ-ААС ГАРГАСАН ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	70%-аас хэтрэхгүй	-	
<b>Г.</b>	<b>ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ</b>			
12	ГАДААД АКТИВ, ПАССИВЫН ЗӨРҮҮ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	(+/-40%)	-	
<b>Е.</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
13	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	-	
<b>Ё.</b>	<b>ӨРИЙН БИЧГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
14	ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	-	
<b>Ж.</b>	<b>ӨГӨӨЖ</b>			
15	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ		-	
16	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		-	

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/  
ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

**ЖУРМЫН 3.4-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН  
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР  
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

0000/СС/ӨӨ

Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
<b>А.</b>	<b>ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>			
1	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	-	
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	-	
3	НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	-	
<b>Б.</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>			
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	-	
<b>В.</b>	<b>АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
5	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү,- дутуу)	-	-	
6	НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	-	
7	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН, ХОЛБОГДОХ НЭГ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	-	
8	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАНХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ НИЙЛБЭР ДҮНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25%-аас хэтрэхгүй	-	
9	ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШИЛ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	-	
10	КОМПАНИЙН ХУВЬЦАА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	-	
11	НЭГ КОМПАНИЙН ГАРГАСАН ХУВЬЦААНААС ХУДАЛДАЖ АВАХ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	-	
12	КОМПАНИЙН ӨРИЙН БИЧИГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	-	
13	ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	-	
14	ББСБ-ААС ГАРГАСАН ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	70%-аас хэтрэхгүй	-	
<b>Г.</b>	<b>ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ</b>			
15	ГАДААД АКТИВ, ПАССИВЫН ЗӨРҮҮ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	(+/-40%)	-	
<b>Д.</b>	<b>ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ</b>			
16	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	80%-аас хэтрэхгүй	-	
<b>Е.</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
17	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	-	
<b>Ё.</b>	<b>ӨРИЙН БИЧГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
18	ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	-	
<b>Ж.</b>	<b>ӨГӨӨЖ</b>			
19	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			-
20	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ			-

**ТАМГА**

ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../НЭР/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ...../НЭР/

ЭДИЙН ЗАСАГЧ...../НЭР/

**ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ**  
/сараар/  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР**  
**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА**

20... оны .....сарын.....өдрөөс .....сарын .....өдөр

№	Валютын төрөл	Худалдаж авсан		Валют				Дундаж ханш	№	Валютын төрөл	Худалдсан		Валют				Дундаж ханш	Ханшийн зөрүүгийн олз/гарз
		хуулийн этгээд	иргэн	ханш	дүн	хөрвүүлснээр					хуулийн этгээд	иргэн	ханш	дүн	хөрвүүлснээр			
						ам.долларт	төгрөгт								ам.долларт	төгрөгт		
1									1									
2									2									
3									3									
4									4									
ДҮН									ДҮН									

Мэдээ гаргасан ажилтны албан тушаал .....

Овог нэр .....

Гарын үсэг.....

/тамга/